

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ХУРИМТЛАЛЫН НЭГДСЭН САНГИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. “Үндэсний баялгийн сангийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 1.1. Үндэсний баялгийн сангаар дамжуулж иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд 2025 оны ногдол ашгийг хуваарилах;	Байгалийн баялаг, ногдол ашиг	Хуримтлалын санд 2024 онд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 495.6 тэрбум төгрөг төвлөрүүлж, Монгол Улсын нийт 3,565.9 мянган иргэнд хуримтлалын нэрийн данс үүсгэж, иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд 138.9 мянган төгрөгийн ногдол ашгийг хуваарилсан.	-	Уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс ногдол ашгийг хуримтлалын санд бүрэн төвлөрүүлсний дараа буюу жилийн эцэст иргэний хуримтлалын нэрийн дансанд 2025 оны ногдол ашгийг хуваарилна.	2025.01.01-2025.12.31	-

2.	Арга хэмжээ 1.2. Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах ажлыг зохион байгуулах;	Засгийн газрын тогтоол Гэрээ	Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд 507.1 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 55.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр баталсан.	2	Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөг байхаар хуульчилсан. Энэхүү эх үүсвэрийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг санхүүжүүлэх хэлбэрээр санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулж, арвижуулах, арга хэмжээ авах агуулга бүхий Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн "Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 228 дугаар тогтоолыг батлуулсан. Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот	2025.01.01-2025.12.31	100%
----	---	--	--	---	---	------------------------------	------

					байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Монголбанк хооронд 98,А/132,2025/195,0525/183 дугаартай "Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ"-г 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан.		
3.	Арга хэмжээ 1.3. Үндэсний баялгийн сангаар дамжуулж иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хүүгийн орлогыг бүртгэх;	Бүртгэлийн тоо	Үндэсний баялгийн сангийн тухай хууль болон Засгийн газрын 2024 оны 179 дүгээр тогтоолын дагуу Сангийн яам, Монголбанк хооронд 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 81-0524/171 тоот "Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ"-г 1 жилийн хугацаатай байгуулсан.	-	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу Хуримтлалын санд 2024 онд төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлж, хуульд заасны дагуу арвижуулах зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 81-0524/171 дүгээртэй "Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ"-г Сангийн яам болон Монголбанк хооронд нэг жилийн	2025.01.01-2025.12.31	70%

					хугацаатай байгуулсан. Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах 2024 оны гэрээний хугацаа 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр дуусгавар болсонтой холбогдуулан тус гэрээний дагуу тооцогдсон хүүгийн өгөөжийг Монголбанк дахь Төрийн сангийн Хуримтлалын сангийн дансанд төвлөрүүлж, тус яам Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10.3-т заасан хүүг иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хуваарилан бүртгэл хөтлөх шаардлагатай байгаа талаар 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1906 тоот албан бичгийг Сангийн яам болон Монголбанканд хүргүүлсэн.		
4.	Арга хэмжээ 1.4. Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцжуулалттай уялдуулах зорилгоор 2025 оны мөнгөн хөрөнгийг орон сууцны	Хуримтлалын сангийн эх үүсвэрээр орон сууцны хөнгөлөлттэй зээлд	Хуримтлалын сангийн 2024 оны эх үүсвэрээс орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлж, 4,183 иргэн ипотекийн зээлд хамрагдсан.	2084	Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах	2025.01.01-2025.12.31	100%

	хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт хөрөнгө оруулах, холбогдох тооцоо судалгаа хийх;	хамрагдсан иргэний тоо			замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөг байхаар хуульчилсан. Энэхүү эх үүсвэрийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг санхүүжүүлэх хэлбэрээр санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулж, арвижуулах, арга хэмжээ авах агуулга бүхий Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн “Хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 228 дугаар тогтоолыг батлуулсан. Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Монголбанк хооронд 98,А/132,2025/195,0525/1 83 дугаартай “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг		
--	---	---------------------------	--	--	---	--	--

					удирдах, арвижуулах ерөнхий гэрээ"-г 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан. Дээрх тогтоол, гэрээний дагуу "Төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны санхүүжилтийн хөтөлбөр"-т хөрөнгө оруулахтай холбогдох үйл ажиллагаа болон Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрхийг Монголбанканд гэрээгээр олгосон тул хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэн, арилжааны банкуудад хуваарилж олгох юм. Ингэснээр иргэд хуримтлалын сангийн эх үүсвэрээр орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломж бүрдсэн.		
		Боловсруулсан судалгаа /тоо/	-	1	Ипотекийн зээлийн бүтээгдэхүүнд нэн тэргүүнд хамрагдах орон сууцгүй, 1 ба түүнээс дээш хүүхэдтэй, ажил эрхэлдэг, өрхийн сарын орлого нь 1-2 сая төгрөг хүртэл, 40 ба түүнээс доош насны өрхийн	2025.01.01-2025.12.31	100%

					тэргүүлэгчтэй зорилтот 17,292 өрхийн мэдээллийг боловсруулан үүнээс дахин төлөвлөлт, нийслэлийн төсөл, дэд төвийн бүсүүдэд амьдарч 4,092 өрхийн мэдээллийг гаргаж Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороонд хүргүүлсэн. Зорилтот бүлгийг тодорхойлох судалгааны хүрээнд анх удаа орон сууц авч буй залуу болон олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлийг тус тус орлогын түвшин, байршлаар тодорхойлсон болно.		
5.	Арга хэмжээ 1.5. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашиг болон бусад нэмэлт орлогоо Хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулахаар хүсэлт гаргасан иргэдийн орлогыг бүртгэхтэй холбоотой	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Өөрийн хүсэлтээр хуримтлалын нэрийн дансанд орлого бүртгэж байгаагүй.	2	Хуримтлалын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 9, 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь	2025.01.01-2025.12.31	100%

	холбогдох арга хэмжээг зохион байгуулах;				удаагийн ногдол ашгаа хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах эсэх талаар “И-Монголиа” цахим системээр дамжуулан иргэдээс баталгаажуулах санал асуулгыг явуулахад 600 иргэн ногдол ашгаа хуримтлуулах санал өгсөн болно. ”Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашгийг Хуримтлалын сангийн хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулах саналыг “И-Монголиа” цахим системээр дамжуулан гаргасан иргэдийн ногдол ашгийг Монголбанкн дах Төрийн сангийн Үндэсний баялгийн сан (Хуримтлалын сан) шилжүүлэх зохицуулалтыг тусгасан Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/874 тоот албан бичгээр яамдаас санал авч, Засгийн газрын, 2025		
--	--	--	--	--	--	--	--

					оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Хуримтлалын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 177 дугаар тогтоолыг батлуулсан.		
6.	Арга хэмжээ 1.6. Хуримтлалын сангийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсөөллийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	Төсвийн төсөл	Хуримтлалын сангийн 2024 оны төсвийн төслийг боловсруулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.	1	Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлд Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөгөөр баталсан. Хуримтлалын сангийн 2026 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн цаглаврын дагуу хүргүүлэхтэй холбоотой орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд Эрдэнэс Монгол ХХК-аас 2026 оны орлогын төсөөллийг ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн. 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Хуримтлалын сангийн	2025.01.01-2025.12.31	100%

					2026 оны орлогын төлөвлөгөөг 435.5 тэрбум төгрөг, хүүгийн орлого 149.7 тэрбум төгрөг байхаар тооцон санал боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн.		
7.	Арга хэмжээ 1.7. Хуримтлалын сангийн сангийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах боломжийг судалж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;	Тайлан	Хуримтлалын сангийн 2024 оны үйл ажиллагааны тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.	1	Хуримтлалын сангийн 2024 үйл ажиллагааны тайланг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1318 тоот албан бичгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. Хуримтлалын сангийн 2025 оны хагас жилийн үйл ажиллагааны тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр бэлдэж байна.	2025.01.01-2025.12.31	70%
8.	Арга хэмжээ 1.8. "Хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг өвлөх, шилжүүлэх, дэмжлэг үзүүлэх хүсэлтийн маягт"-ыг боловсруулж, батлуулах;	Батлуулсан маягтын тоо	Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам батлагдсан.	1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн "Маягт батлах тухай" А/54 дүгээр тушаалаар Хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг өвлөх	2025.01.01-2025.12.31	100%

					хүсэлтийн маягтыг батлуулсан. Мөн “Хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг гэр бүлийн гишүүнд шилжүүлэх хүсэлт”, “Хуримтлалын сангаас дэмжлэг авах хүсэлт”-ийн маягтын загварыг тус тус боловсруулсан.		
9.	Арга хэмжээ 1.9. Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өсгөх, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлэх талаарх боломжийг судлах;	Боловсруулсан баримт бичиг	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж, Банкны тухай хуулийн 3.1.20-д арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжид хөрөнгө оруулж болно гэж тус тус заасан.	-	“Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 192 дугаар тогтоолоор батлуулсан.	2025.01.01-2025.12.31	100%
10.	Арга хэмжээ 1.10. Хуримтлалын сангийн талаарх олон улсын туршлага, хууль эрх зүйн орчин, холбогдох тайлан, мэдээ, дүн шинжилгээ, үндэсний болон олон улсын байгууллагын судалгаа, статистик, тоон	Судалгаа	Египет, Норвеги, Бүгд Найрамдах Сингапур Улсын “Сингапурын хамтын ажиллагаа”-ны байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк, Европын холбоо, Европын Комиссын Ази, номхон далайн бүс	1	Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл, холбогдох тооцоо судалгааг боловсруулсан. Монгол Улсын Ерөнхий Сайд 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Улсын Их	2025.01.01-2025.12.31	100%

	мэдээллийг судлах, санал боловсруулах;		нутаг Ойрх Дорнодыг хариуцсан Олон Улсын түншлэлийн газар зэрэг олон улсын байгууллагуудын туршлага судалсан. Мөн Санхүү, эдийн засгийн их сургуулийн судалгааны багаар “Орон сууцны санхүүжилтийн өнөөгийн байдал, боловсронгуй болгох арга зам” 2024 судалгаа, Монголбанк болон бие даасан судлаачдын багаар Орон сууцны санхүүжилтийн тогтолцооны экосистем, шинэчлэх боломжийн судалгааг тус тус хийсэн.		Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд Хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар” мэдээлэл хийхтэй холбоотой Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар нэгдсэн мэдээлэл бэлдэж ажилласан. Сүүлийн жилүүдэд баялгийн сангуудын удирдаж буй хөрөнгийн хэмжээ тогтвортой өсч өдгөө дэлхий дахинд 100 гаруй сан нийтдээ 13 их наяд ам.долларын хөрөнгө удирдаж байна. Энэ нь дэлхийн ДНБ-ний бараг 10 орчим хувийг хамарч байгаа нь тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө асар их болсныг илтгэнэ. Баялгийн сангуудын хөрөнгийн эх үүсвэр нь улс орны онцлог болон эдийн засгийн бүтэцтэй уялддаг. Жишээлбэл,	
--	--	--	---	--	--	--

					газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын экспортын орлогод суурилсан баялгийн сангуудын дунд Норвегийн "Government Pension Fund Global" (GPFG), Абу Дабигийн "Abu Dhabi Investment Authority" (ADIA), Кувейтын "Kuwait Investment Authority" (KIA), Катарын "Qatar Investment Authority" (QIA) зэрэг нэр хүндтэй сангууд багтдаг. Эдгээр нь үндсэндээ байгалийн нөөцөөс бий болсон орлогыг ирээдүйн хэрэгцээнд зориулан хуримтлуулж, эрсдэл багатай, өгөөж өндөртэй байдлаар олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг. Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний тогтолцоог сайжруулах, орон сууцны хөнгөлөлттэй ипотекийн зээлийг зорилтот бүлэг рүү чиглүүлэх, орон сууцны тухай хууль эрх зүйн орчны сайжруулах хүрээнд ҮБСОСҮХ-ны ажлын албатай хамтран		
--	--	--	--	--	--	--	--

					ажиллаж, дараах уулзалт, арга хэмжээнд оролцоог хангасан. Бүгд Найрамдах Казахстан Улсын орон сууцны хөнгөлөлттэй зээл болон хадгаламжийн талаар мэдээлэл, судалгаа боловсруулсан. Бүгд Найрамдах Казахстан Улс зорилтот бүлгийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: -олон хүүхэдтэй гэр бүл -хөгжлийн бэрхшээлтэй иргэн -хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд өсгөж буй гэр бүл -өнчин, эцэг эхийн хараа хяналтгүй үлдсэн хүүхдүүд -залуу гэр бүл -анх орон сууц авч байгаа иргэн -ажилтны орон сууцны хөнгөлөлттэй зээл -бага орлоготой өрх зэрэг болно.		
Зорилт 2. “Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ” зорилтын хүрээнд”							
1.	Арга хэмжээ 2.1. Хуримтлалын нэгдсэн сангийн мэдээллийн нэгдсэн санг шинээр нэвтрүүлэх ажлыг үе	Боловсруулсан баримт бичиг, программ хангамж	Хуримтлалын нэгдсэн сангийн мэдээллийн нэгдсэн санг шинээр бий болгож байгаа.	2	Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 224 дүгээр тогтоолоор Хуримтлалын сангийн үйл ажиллагаанд	2025.01.01-2025.12.31	100%

	шаттай хэрэгжүүлэх;	авч			шаардлагатай программ хангамж хөгжүүлэлтийг Санхүүгийн мэдээллийн технологийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газар хариуцан ажиллахаар зохицуулсан. Энэхүү ажлын хүрээнд тус яам Санхүүгийн мэдээллийн технологийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газартай “Хамтран ажиллах гэрээ” болон “Системийн хөгжүүлэлт, тасралтгүй ажиллагааг хангах гэрээ”-г байгуулахаар ажиллаж байна. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/158 дугаар тушаалаар хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн системийн бодлогын даалгавар боловсруулах зөвлөх сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсэг хуримтлалын сангийн мэдээллийн мэдээллийн нэгдсэн системийн программын бодлогын даалгаврыг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх		
--	------------------------	-----	--	--	---	--	--

					бодлогын зөвлөхийг сонгон шалгаруулсан. Мөн хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн системийн программын бодлогын даалгаврыг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх бодлогын зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулж, батлуулсан. Хуримтлалын нэрийн дансны бүртгэл хийх талаарх программын ажлын даалгаврын төслийг боловсруулан Санхүү мэдээлэл технологийн төв УТҮГ-т хүргүүлсэн.		
2.	Арга хэмжээ 2.2. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор иргэд, олон нийтэд сурталчлан таниулах;	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3	Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцаас “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 93 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар ирүүлсэн асуулгын хариуг 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/606 дугаар	2025.01.01-2025.12.31	100%

					албан бичгээр хүргүүлсэн. -2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хуримтлалын сангийн үйл ажиллагааны талаар иргэдэд зориулсан постер мэдээлэл бэлтгэсэн. -Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр “Нээлттэй нийгэм форум” өдөрлөгт 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хуримтлалын сангийн талаар мэдээлэл танилцуулсан.		
3.	Арга хэмжээ 2.3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;	Хамтран ажилласан байгууллагын тоо	Улсын бүртгэлийн ерөнхий газар, И-Монгол академи, Үндэсний дата төв, Санхүүгийн мэдээллийн технологийн төв, Монголбанк, Эрдэнэс Монгол ХХК болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	2	Тус яам Монголбанк, Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд Хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцан санал солилцох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 5 удаа уулзалт зохион байгуулсан.	2025.01.01-2025.12.31	100%

1.	Арга хэмжээ 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна;	Боловсруулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг тайлагнаж дүгнүүлсэн.	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажилласан.	2025.01.01-2025.12.31	100%
2.	Арга хэмжээ 3.2. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлэх;	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн.	-	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн.	2025.01.01-2025.12.31	100%
3.	Арга хэмжээ 3.3. Дээд газар, холбогдох байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг ханган ажиллах;	Тогтоол, шийдвэрийн тоо	Ирсэн албан бичиг, тогтоол, шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаж байна.	2	Дээд газар, бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, санал, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд судалж, шийдвэрлэсэн.	2025.01.01-2025.12.31	100%


Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Үндэсний баялгийн сан, Хуримтлалын	Холбогдох баримт бичиг, судалгаа,	Холбогдох баримт бичиг,	1	Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Хуримтлалын сантай	2025.01.01-2025.12.31	100%

	сантай холбоотой хууль, тогтоомжийг судлах, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх;	тайлан судалсан эсэх (Тийм:1 / Үгүй:0)	судалгаа, тайланг тухай бүр судалсан.		холбоотой хууль, тогтоомжийг судлан ханган хэрэгжилтийг ажиллаж байна.		
2.	Арга хэмжээ 2. Бусад цаг үеийн сургалтад хамрагдан ур чадвараа дээшлүүлэх;	Хамрагдсан сургалтын тоо	-	-	Байгууллагаас зохион байгуулсан цаг үеийн сургалтанд тухай бүр хамрагдсан.	2025.01.01-2025.12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын
Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга
(Албан тушаал)

А.Хишигбаяр /  /
(Нэр, гарын үсэг)

/ 2025.06.13 /
(Огноо)

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХУРИМТЛАЛЫН САНГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХУРИМТЛАЛЫН
НЭГДСЭН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын хуримтлалын
нэгдсэн сангийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуу лж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Үндэсний баялгийн сангийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах” зорилтын хүрээнд					
1.	Арга хэмжээ 1.1. Үндэсний баялгийн сангаар дамжуулж иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд 2025 оны ногдол ашгийг хуваарилах;	—	—	—	
2.	Арга хэмжээ 1.2. Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах ажлыг зохион байгуулах;	60	10	70	70
3.	Арга хэмжээ 1.3. Үндэсний баялгийн сангаар дамжуулж иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хүүгийн орлогыг бүртгэх;	42	7	49	49
4.	Арга хэмжээ 1.4. Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцжуулалттай уялдуулах зорилгоор 2025 оны мөнгөн хөрөнгийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт хөрөнгө оруулах, холбогдох тооцоо судалгаа хийх;	60	10	70	70

5.	Арга хэмжээ 1.5. Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн энгийн хувьцааны 2024 оны 2, 3 дахь удаагийн ногдол ашиг болон бусад нэмэлт орлогоо Хуримтлалын нэрийн дансандаа хуримтлуулахаар хүсэлт гаргасан иргэдийн орлогыг бүртгэхтэй холбоотой холбогдох арга хэмжээг зохион байгуулах;	60	10	70	70
6.	Арга хэмжээ 1.6. Хуримтлалын сангийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсөөллийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	60	10	70	70
7.	Арга хэмжээ 1.7. Хуримтлалын сангийн сангийн тайланг хагас, бүтэн жилээр гаргах боломжийг судалж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;	46	7	49	49
8.	Арга хэмжээ 1.8. "Хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгийг өвлөх, шилжүүлэх, дэмжлэг үзүүлэх хүсэлтийн маяг"-ыг боловсруулж, батлуулах;	60	10	70	70
9.	Арга хэмжээ 1.9. Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг өсгөх, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийг нэмэгдүүлэх талаарх боломжийг судлах;	60	10	70	70
10.	Арга хэмжээ 1.10. Хуримтлалын сангийн талаарх олон улсын туршлага, хууль эрх зүйн орчин, холбогдох тайлан, мэдээ, дүн шинжилгээ, үндэсний болон олон улсын байгууллагын судалгаа, статистик, тоон мэдээллийг судлах, санал боловсруулах;	60	10	70	70
Зорилт 2. "Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ" зорилтын хүрээнд"					
1.	Арга хэмжээ 2.1. Хуримтлалын нэгдсэн сангийн мэдээллийн нэгдсэн санг шинээр нэвтрүүлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлэх;	60	10	70	70

2.	Арга хэмжээ 2.2. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор иргэд, олон нийтэд сурталчлан таниулах;	60	10	70	70
3.	Арга хэмжээ 2.3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төрөлжсөн сан болох Хуримтлалын сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;	60	10	70	70
Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд					
1.	Арга хэмжээ 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна;	60	10	70	70
2.	Арга хэмжээ 3.2. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлэх;	60	10	70	70
3.	Арга хэмжээ 3.3. Дээд газар, холбогдох байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн биелэлтийг ханган ажиллах;	60	10	70	70
Дундаж оноо:				67.2	67.2

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Арга хэмжээ 1. Үндэсний баялгийн сан, Хуримтлалын сантай холбоотой хууль, тогтоомжийг судлах, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх;	100	15	15
2.	Арга хэмжээ 2. Бусад цаг үеийн сургалтад хамрагдан ур чадвараа дээшлүүлэх;	100	15	15
Дундаж оноо			15	15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	7
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	7
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	7
Дундаж оноо		7	7

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	67.2
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	97.2
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		97.2

Үнэлгээ өгсөн:

Нийгмийн даатгал, хуримтлалын
сангийн бодлогын газрын дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга


(гарын үсэг) /В.Рэнцэнханд/
(албан хаагчийн нэр)

2025.06.13 (оноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын

Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)


/А.Хишигбаяр/
(албан хаагчийн нэр)

2015.06.13 (огноо)

Үнэлгээг хянасан:

.....
(албан тушаал)

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:


(гарын үсэг)

/Б.Түвшиноров/
(албан хаагчийн нэр)

2015.06.10 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

.....
(албан тушаал)


(гарын үсэг)

/Б.Самбуурагч/
(албан хаагчийн нэр)

2015.06.10 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төрийн нарийн
бичгийн дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч


(гарын үсэг)

/Л.Мөнхзул/
(албан хаагчийн нэр)

2015.06.10 (огноо)

ATA12944 9132155 9024070403